

ШЭНЬЯН БУЮУ МҮГДЭН ХОТ

С.МЯГМАРСҮРЭН*

Шэньян хот нь Ляонин муждаа төдийгүй, Зүүн хойд Хятадын эдийн засаг, соёл, зам харилцаа бизнес худалдааны төв бөгөөд Бүх Хятадын хэмжээний аж үйлдвэрийн гол хот, түүх соёлын нэрт хот юм. Шэньян хотод нийт 9 дүүрэг, нэг хот, гурван хошуу харьяалагддаг. Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ нь 13 мянган хавтгай дөрвөлжин километр, төвийн дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээ 3495 хавтгай дөрвөлжин километр. Хүн ам нь 7.2 сая, төвийн дүүрэгтээ л гэхэд 5.6 сая орчим хүн оршин суудаг.

Шэньян хот нь Хятадын Зүүн хойд хэсгийн нутгийн өмнө талд Ляонин мужийн нутгийн дунд хэсэгт байрладаг, газар нутгийн онцлогийн хувьд тэгш тал газраас бүрдэх ба уул нуруу дов гүвээ нь ихэвчлэн нутгийн зүүн өмнөд хэсгээр төвлөрсөн байдаг. Ляохө (Liao He), Хунхө (Hong He), Сюшуйхө (Xushui He) зэрэг гол мөрөн нутаг дэвсгэр дээгүүр нь дайран өнгөрдөг. Цаг агаарын хувьд сэрүүн бүсийн хагас чийглэг эх газрын уур амьсгалтай. Жилийн температур -26 С - 36 С хооронд хэлбэлзэх ба дулааны дундаж хэмжээ 8,3 С байдаг. Шэньян хот орчимд жилдээ дунджаар 680-560 мм хур тунадас буудаг. Энэ хэмжээ нь нутгийн зүүн өмнөд хэсгээс нутгийн баруун хойд хэсэг рүү шилжих тусам аажмаар буурдаг. Хотын төвөөс Дунлин Хунхө (Dongling Honghe) голын орчмоор хур бороо их ордог. Синьмин хошууны хойд хэсгийг хур бороо хамгийн багатай хэсэг гэж үздэг. Нутаг дэвсгэрээс хамааран хур тунадасын нийт зөрүү 150 мм орчим байдаг. Хотын орчмоор жилийн дундаж хур тунадасын хэмжээ 715,5 мм орчим байдаг. Энэ нь Ляонин мужийн баруун хэсгээс их байх ба Зүүн хэсгийн уулархаг бүс нутагтай харьцуулахад харьцангуй бага байдаг ажээ.

Жилийн дундаж хур тунадасны хэмжээ Чао Янтай (Chao Yang) харьцуулахад 50%-

иар их Дань Дунтай (Dan Dong) харьцуулахад 30%-аар бага байдаг байна. Жилийн турш 183 хоног цасгүй байдаг. Улиралын салхины нөлөөгөөр дулааны зөрүү нэлээн ихтэй байдаг ба дөрвөн улиралын ялгаа нэлээд их байдаг байна.

Шэньян хот нь хол ойрд нэртэй түүх соёлын дурсгалт хот билээ. Газар нутгийн хувьд эртний Шэньшуй (Shen Shui) мөрний хойд хэсэг одоогийн Хунхө мөрний салаанд байрлах тул Шэньян хэмээх нэрийг авчээ.

Шэньяны газар нутаг нь Ляо Хө мөрний сав газрын эртний соёлыг бий болгосон өлгий нутаг бөгөөд Хятад үндэстний үүсэн бий болсон газар нутаг юм.

Синьлө (Xinle)-ийн туурьнаас олдсон эд өлгийн зүйлсээс үзэхэд 7200 жилийн өмнө энэ газар нутаг дээр хүн төрөлхтөн амьдран суурьшиж байсан нь харагдаж байна.

Манай эриний өмнөх 229 оноос өмнө Хоучөн (Houcheng) хотыг байгуулж эхэлсэн цагаас Шэнь Яны хотын анхны суурь тавигдаж байсан түүхтэй. Эдүгээ уг хот нь байгуулагдсан цагаас хойш 2300 жилийн нүүр үзээд байна. Шэнь Ян хот нь нэг Төр хоёр Хааныг төрүүлсэн нутаг хэмээн хүндлэгдэн нэрлэгддэг билээ.

1625 онд Чин улсын их хааны байгуулсан Алтан улс буурь сэлгэн энд нүүн ирсэн цагаас тус хот нэрээ өөрчлөн Шөнзин (Sheng Jing) хэмээх нэртэй болжээ. Хун тайж энэ газарт улсынхаа нэрийг Чин улс болгон өөрчилжээ. 1644 онд Чин улсын цэрэг газар нутгаа тэлж боомтын цаана гарч Бээжинд тэндээ нийслэл хотоо байгуулсан цагаас Шөнзин хот нь дэд нийслэлийн статустай явж иржээ. Чин улсын эхэн үеийн хааны ордон нь БНХАУ-ын Хааны ордны барилгын цогцолборуудаас нэлээн бүрэн бүтэн хадгалагдаж үлдсэн хоёрхон газрын нэг нь юм.

БНХАУ байгуулагдсан эхний үеэс уг хотыг Тоног төхөөрөмжийн аж үйлдвэрлэлээр гол болгосон бүх Хятадын хүнд аж үйлдвэрийн бааз суурь хот байхаар хөгжүүлж ирсэн байна.

* С.Мягмарсүрэн. ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Өнөөг хүртэл хөгжин хэдэн арван жилийн нүүр үзсэний дараа өнөөдөр тус хотод 142 төрлийн үйлдвэрлэл хөгжиж байна. Том хэмжээний 3300 үйлдвэртэй бөгөөд орон нутгийн ДНБ нь 224 тэрбум юаниас давсан байна.

Сүүлийн жилүүдэд Шэньян хотын намын хороо, хотын захиргаанаас Шэньян хотыг хуучин аж үйлдвэрийн бааз сууринд түшиглэн аж үйлдвэрийг сэргээн хөгжүүлэх зорилтыг биелүүлэхийн тулд өөрчлөлт шинэчлэл нээлттэй бодлогод нийцүүлсэн аж үйлдвэрийн хот байгуулах ерөнхий төлөвлөгөөний дагуу төрийн өмчит эдийн засагт хийх стратегийн шинжтэй зохицуулалтыг түргэсгэж, гадаадын хөрөнгө оруулалтай болон хувийн эзэмшлийн аж үйлдвэрээс бүрэлдсэн эдийн засгийн шинэ бүтцийг бий болгон хөгжүүлж байна.

Хотын хөгжлийн орон зай их байгаа ба үйлдвэрлэлийн салбарын байршуулалт хүрээгээ тэлэн хөгжиж байна. Үүнд автомашин үйлдвэрлэл болон сэлбэг хэрэгсэл тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, цахим мэдээлэл, хими эмийн үйлдвэр зэрэг салбарууд амжилттай хөгжиж байна. Эдгээр салбарууд нь бүх хотын эдийн засгийн түргэн хөгжлийн тулгуур аж ахуй болтлоо хөгжиж чадсан байна. Техник технологийн шинэ санаачлагыг үйлдвэрлэлд өргөн нэвтрүүлж, аж үйлдвэрийн шинжлэх ухааны судалгаа зэргийг тасралтгүй хөгжүүлж байгаагаас зах зээл дээр өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн, аж үйлдвэрүүд ар араасаа цувран бий болсоор байна. Хотын дэд бүтцийг хурдацтай хөгжүүлснээр хотын зөөлөн орчны бүтээн байгуулалт улам илүү сайжирсан байна.

Шэньян хотын эдийн засаг нийгмийн хурдтай хөгжил, хотын ард түмний аж амьдралд сайнаар нөлөөлж хотын нийгэм эдийн засаг хөгжлийнхөө дардан замдаа шуудран оржээ. Энэ хугацаанд Шэньян хот нь БНХАУ-ын Байгаль орчны хамгаалах үлгэр жишээ хот, Улсын Ойн хот зэрэг хүндэтгэлийг удаа дараа хүртэж байсан төдийгүй хоёр жил дараалан бүх Хятадын шилдэг зуун хотын эхний арван байрт орж, улсын хэмжээний арван хамгийн өрсөлдөхүйц хэмжээний хотын эгнээнд ороод байна.

Эдийн засгийн глобалчлал эрчтэй явагдаж байгаа өнөөдөр Зүүн хойд Хятадын аж үйлдвэрийн хуучин бааз суурийг бүх талаар сэргээн хөгжүүлэх стратегийн чухал цаг тохиолын өмнө Шэньян хотын захиргаа 2010 гэхэд Шэньян хотыг Бүх улсын тоног төхөөрөмж үйлдвэрлэл, Зүүн хойд Хятадын

Худалдаа бизнес, банк санхүүгийн 3 дахь том хот болгон хөгжүүлэх тухай шийдвэрийг албан ёсоор гаргасан байна. Ингэснээр Шэньян хот нь Ляонин муждаа төдийгүй Зүүн хойд Хятадын нийт бүс нутгийн хөгжлийн туйл нь болох юм. Шэньян хот нь газар нутгийн ашигтай байрлал, аж үйлдвэрийн баялаг бааз суурь, шинжлэх ухаан технологийн хүчин чадал, боловсронгуй болсон зах зээлийн бүтэц, зам харилцааны сүлжээний хөгжингүй байдал зэрэгтэй түшиглэн БНХАУ-даа хөрөнгө оруулалтыг хамгийн ихээр татаж чадсан бүс нутаг болж чадах нь дамжиггүй.

Шэньян хот нь Бүх Хятадын түүх дурсгал соёлын нэртэй хот бөгөөд Хятадын аялал жуулчлалын анхны шилдэг хотуудын нэг тул, аялал жуулчлалын нөөц баялаг ихтэй. Эртний түүх дурсгалын газруудаас дурдвал: Фулин, Жаолиний булш, Синлөгийн туурь музей, Емаотайляогийн булш, Өнөд амгалан гүүр зэргийг дурдаж болно.

Шэньян хотын хааны ордон нь Хятад улсын хэмжээнд өнөөг хүртэл хадгалагдаж ирсэн Хааны ордны цогцолборын нэг нь тул түүх соёлын талаар асар үнэ цэнэтэй байдаг бөгөөд Чин улсын их хаан Нурхачи болон түүний хүү Хун тайжийн төр барихдаа залран сууж байсан Хааны ордон юм. Фулин, Жаолин зэрэг булшнууд нь хол ойрд “Боомтын гаднах гурван булш” гэж нэр алдаршсан булшнуудын хоёрынх нь байрлаж байгаа газрууд юм. Эдгээр булш нь Хятадын эртний барилгын өнгө төрхийг хадгалсан үндэсний онцлогтой хаадын булш юм. Эдгээр нь Чин улс нийслэлээ Бээжинд нүүлгэхээс өмнө үлдсэн булшнуудаас хамгийн том нь юм.

Синьлөгийн туурь нь Хятад улсын Зүүн хойд нутгийн шинэ чулуун зэвсгийн үеийн хамгийн эртний эхийн эрхэт овгийн нийгэм оршин тогтнож байсныг харуулдаг эртний овгийн туурь юм. Эдүгээгээс 7200 гаруй жилийн өмнөх үед хамрагддаг. Жөнзязавзийн хүрэл хутгатай булш нь нь Шөн Ян хотын Хун дүүрэгт байрлах ба Хавар намрын Байлдаант улсын үеийн эртний булшнуудын байрладаг газар юм. Емаотайляогийн булшнууд нь Факу хошуунд байрлах ба Ляосигийн сайд Сяо И болон түүний гэр бүлийн гишүүдийн оршуулгын газар юм.

Өнөд амгалан гүүр нь мөн л Хун дүүрэгт байрлах бөгөөд Шөн Ян хотын нутаг дэвсгэр дээр бүрэн бүтэн хадгалагдан үлдсэн Чин Улсын эхэн үеийн нуман хэлбэрт чулуун гүүр юм.